



СЭЛЭНГЭ АЙМАГ  
БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/97

Баруун хараа

Хортон мэрэгчидтэй тэмцэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын зарим нутаг дэвсгэрт хортон мэрэгчдийн тоо толгой тархац бэлчээр, тариалангийн талбайд үлэмж хохирол учруулахуйц хэмжээгээр өсч байгаа тул бэлчээр, тариалангийн талбайг мэрэгчдээс хамгаалах арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч

М. Бямбаа

Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга

Н. Давааням

Хөдөө аж ахуйн тасгийн дарга

Гишүүдэд

М. Бумцэнд

Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Л. Баярсайхан

Хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтэн

Л. Занданбат

Хараа 1 дүгээр багийн Засаг дарга

Б. Түшигжаргал

Баян 2 дугаар багийн Засаг дарга

Б. Болортуяа

Гонир 3 дугаар багийн Засаг дарга

2. Ажлын хэсэгт даалгах нь:

а/ Мэрэгчидтэй тэмцэх ажлын төлөвлөгөө гарган, мэрэгчдийн тоо толгой, тархац хэт олширсон газрын талбайн зураглал гаргах

б/ Хөнөөлт мэрэгчид хэт олширсон газрын ойролцоох тариаланчид, малчдыг оролцуулсан ажлын хэсгүүдийг зохион байгуулах

в/ Мэрэгчидтэй тэмцэх ажлын талаар таниулга, сэрэмжлүүлэг хийх

г/ Заавар зөвлөмжийн дагуу мэрэгчидтэй тэмцэх шаардлага хангасан техник, хүн, хүчийг зохион байгуулж гэрээ хэлцэл хийх

д/ Мэрэгчидтэй тэмцэх ажлын арга технологи, Хүнс хөдөө аж ахуйн газраас өгөгдсөн зааврын дагуу мэргэжлийн арга зүйгээр хангах

е/ Мэргэжилтэн, малчид оролцуулсан хээрийн ажлын бүлэг байгуулан өвөлжөө, хаваржаанаас алслагдсан газрын мэрэгчидтэй тэмцэх ажлыг байгаль орчинд халгүй механик, биологийн аргаар технологийн хугацааг алдалгүй гүйцэтгэх

ё/ Гэрээ хэлцэл хийсэн ажлын гүйцэтгэлийг үнэлэх дүгнэх

3. Байгаль орчинд халгүй арга технологи, механик, биологийн аргаар мэрэгчидтэй тэмцэх, хөнөөлт мэрэгчдийн тоог тухайн орчинд байгалийн тэнцвэрт хэмжээнд зохицуулан устгах ажилд хяналт тавихыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч /М. Бумцэнд/-д үүрэг болгосугай.

4. Дээрх зохион байгуулж буй нийтийг хамарсан ажилд сумын зорилтот бүлгийн өрхөөс сонгон 10 иргэнийг 5 хоногийн хугацаатай ажиллуулж холбогдох материалыг бүрдүүлэн аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт хүргүүлэхийг хөдөлмөр эрхлэлтийн мэргэжилтэн /Л. Баярсайхан/-д даалгасугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын даргын үүрэг гүйцэтгэгч /Б. Эрдэнэбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С. АРИУНБАТ